



Г НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингалтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99,
<http://www.ulaanbaatar.mn>

2019.01.28 № 03/312

танай _____ -ны № _____ -т

Г Тэмдэглэл хүргүүлэх тухай


Г НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлийн II дахь хэсгийг хүргүүлж байна.

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингалтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбогдуулан гарсан хуралдааны тэмдэглэлийг анхааралтай судлан өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хяналт тавьж ажиллахыг мэдэгдэж байна.

Хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, сургалтын хэрэгцээг тодорхойлох, гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэхэд онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

Хавсралт 2 хуудастай.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлд:

"II. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов:

1.1. төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төрийн бүх шатны байгууллага Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;

1.2. төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн (мерит) болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон Төрийн албаны тухай хуулийг чанд баримтлах;

1.3. төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгаанд үндэслэн Төрийн албаны хуульд заасан шаардлага хангаж байгаа албан тушаалтнуудыг зохих журмын дагуу томилох, шаардлага хангахгүй байгаа албан тушаалтнуудыг үүрэгт ажлаас чөлөөлж, дүнг 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;

1.4. төрийн захиргааны албан тушаалын байнгын ажлын байранд гэрээт ажилтан ажиллуулж хууль тогтоомж зөрчдөг үйлдлийг таслан зогсоох, ийм гэрээт ажилтны гэрээг цуцалж уг орон тоог хуульд заасан журмын дагуу нөхөх;

1.5. төрийн захиргааны байгууллагын ашиглаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцон шинэчлэх арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэх;

1.6. төрийн байгууллагын үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийсний үндсэн дээр боломжит үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

1.7. төрийн албаны хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг мэргшүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллуулах;

1.8. төрийн бүх шатны албан хаагчийг хамруулах сургалтын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан төлөвлөх, албан хаагчдыг сургалтад хамруулах, хэрэгцээ шаардлага, үр дүн нь тодорхой бус сургалтад оролцуулахаас татгалзах;

1.9. Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх, үнэлгээний дагуу цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн хэрэгжүүлж байх;

1.10. төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулах, хагас, бүтэн жилээр явцын хяналт-шинжилгээ хийж үр дүнг албан хаагчдад тогтмол мэдээлж байх;

1.8 төрийн бүх шатны албан хаагчийг хамруулах сургалтын хуваарийг жил бүрийн 1.11. төрийнд албан хаагчийн сэхилгээ хариуцлагыг дээшлүүлэх байгууллага, нутаг дэвсгэртээ хууль хэлбэрэлтгүй хэрэгждэг соёлыг тогтоож иргэдийн итгэлийг хүлээсэн, ил тод хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр өөрийн эрх хэмжээний хүрээнд үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлэх; төрийн гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх, үнэлгээний дагуу цалин урамшуулал, хариуцлагын ясуудлыг хувь, дүрэм, хувьсамд нийцүүлэн хэвшүүлэх.

2. Төрийн байгууллагуудын байрлаж байгаа барилга байгууламж, өрөө хөдөлжилж, тасалгааны эрүүл ахуй, аюулгүй байдлын судалгаа гаргаж, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийн талаарх стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Θ.Энхтувшинд даалгав.

3. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт даалгав:

3.1. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог тухайн нутгийн дэвсгэрийн нийгэм, здийн засгийн онцлог, хүн амын тоо, нягтаршил, ажлын ачаалал зэргийг харгалzan шинэчлэн боловсруулж 2019 оны 5 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

3.2. төрийн жинхэнэ албан хаагчдад зориулсан сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалzan төрийн албан хаагчийг ангилал тус бүрээр мэргшүүлэх сургалтад хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулах;

3.3. эрх мэдлийн төвлөрлийг сааруулах хүрээнд орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоотой төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын талаар судалж, холбогдох санал, дүгнэлтээ 2019 оны 5 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР